



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/448

Улаанбаатар хот

**Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын
эргэлтийн бус хөрөнгийг балансаас
балансад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 50,549,000 (тавин сая таван зуун дөчин есөн мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар (П.Очбадрах)-ын балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар (П.Очбадрах)-т даалгасугай.

3.Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар (Р.Отгонжаргал)-т, Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар (П.Очбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001208

1119282495 ☎ 2576689

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн А/НХБ дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон огноо		Хэмжих нэгж	Тоо шрхэт	Нэгж үнэ	Бүгд үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Хөрөнгө хүлээн авагч байгууллага	/төгрөгөөр/
		2019	2020								
1	Рам /Лэд дэлгэц/	2019	2020	ш	1	640,500.00	640,500.00	245,525.00	394,975.00	Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар	
2	Төхөөрөмж Лэд дэлгэц	2019	2020	ш	1	880,000.00	880,000.00	337,333.41	542,666.59		
3	Тэжээлийн блок Лэд дэлгэц	2019	2020	ш	1	750,500.00	750,500.00	287,691.59	462,808.41		
4	Удирдлага Лэд дэлгэц	2019	2020	ш	1	1,925,000.00	1,925,000.00	737,916.59	1,187,083.41		
5	Таблет	2019	2020	ш	1	799,000.00	799,000.00	266,333.33	532,666.67		
6	Лэд дэлгэц	2019	2020	ш	25	1,822,160.00	45,554,000.00	17,462,366.59	28,091,633.41		
		Тоног төхөөрөмжийн дүн					50,549,000.00	19,337,166.51	31,211,833.49		
		Нийт дүн					50,549,000.00	19,337,166.51	31,211,833.49		